



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/40/СТА-ТШЗ

Цахим хуудас: [Bayankhongor@
audit.gov.mn](mailto:Bayankhongor@audit.gov.mn)

Баянхонгор хот
2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Аудитор: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	11
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	19



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2020.02.27 № 1/176

танай _____-ны № _____-т

Г _____ Г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Баянхонгор аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул "Хязгаарлалттай" санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн ИТХ-ын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус салбарт мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

-Гүйцэтгэсэн горим сорилын дүнд илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн,

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\
005020128

-Төсвийн зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл дутуу, шатахууны замын хуудсыг бүрэн бичээгүй, нярвын тайлан гаргалт хангалтгүй ,тайлангаарх материалын орлого зарлагыг хүлээн авсан , өгсөн гарын үсэггүй зэрэг нь тухайн бараа материалын орлого, зарлага үнэн зөв эсэхийг нотлох боломжгүй

- ИТХ-ын төлөөлөгч нарын тойрогтоо ажиллах зардалд 123000,0 мянган төгрөг батлагдсаныг бүрэн авч зарцуулсан байхад 12 төлөөлөгч зарцуулалтын тайлан ирүүлж , 29 төлөөлөгч 87000,0 мянган төгрөгийн зардлын зарцуулалтын тайлан ирүүлээгүй , ИТХ-ын хуралдааны зардалд 10000,0 мянган төгрөгийн төсөв батлагдаж 9443,0 мянган төгрөгийн зарцуулалт гарснаас 1 удаагийн 664,6 мянган төгрөгийн зарцуулалтад тушаал гарч, 8778,4 мянган төгрөгийн зарцуулалт шийдвэргүй

- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар ажил гүйлгээг тооцоо үүсгэлгүй зардалд бичсэн, төсвийн хөрөнгөөр худалдан авсан Соёрхол тэмдэг, "Хүндэтгэл"-ийг бараа материалын дансанд орлого аваагүй зарцуулж шууд зардлаар бүртгэсэн, хурлын хуралдааны хоолны зардлыг төсвийн захирагчийн шийдвэргүйгээр зарцуулсан зэрэг зөрчлүүдэд зөвлөмж өгсөн байхад хэрэгжүүлээгүй, тайлант онд худалдан авсан Соёрхол тэмдэг Хүндэтгэлийг орлого аваагүй, зарцуулалтын анхан шатны баримтууд бүрэн байхгүй байна.

Дээрх алдаа, зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн толилуулгын Оршин байх, Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Үнэлгээ, Хэмжилт, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

Аудитын тайлан

2.1. Оршил

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ИТХ-ын нарийн бичгийн дарга, төсвийн менежер Т.Эрдэнэбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 18-наас 2020 оны 02 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27 -ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Цэцэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн 10/95 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор аймгийн ИТХ нь Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлж төлөвшүүлэх, аймаг, орон нутгийнхаа нийгэм эдийн засгийг хөгжүүлж, ард иргэдийн төлөөлөх эрхийг хангаж ажиллах эрхэм зорилгын дор “Нутгийн өөрөө удирдах байгууллагын манлайлалд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх жил” болгох зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Баянхонгор аймгийн ИТХ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн ИТХ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ний Acolous программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор аймгийн ИТХ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 32 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “их” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 643338,4 мянган төгрөгөөс тооцон 12866,8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 12866,8 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн шатанд сонгосон суурь, материаллаг байдлыг тооцох хувийг өөрчлөөгүйтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9371,8 мянган төгрөгөөр буюу 28,4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	2,7	2,7	0
Урьдчилгаа	251,1	0	-251,1
Бараа материал	11382,2	11382,2	0
Үндсэн хөрөнгө	234733,8	245169,8	10436,0
Үндсэн хөрөнгийн элэгдэл	-213379,4	-214192,4	-813,0
Нийт хөрөнгө	32990,5	42362,3	9371,8
Өр төлбөр	1046,9	625,8	-421,1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	31943,5	41736,5	9793,0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	32990,5	42362,3	9371,8

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 10436,0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 3420,0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, үнэ төлбөргүй орлогоор 17515,9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 10500,0 мянган төгрөгийн хөрөнгө хасагдсанаас шалтгаалжээ.

Биет бус хөрөнгөнд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 41736,5 мянган төгрөг болж 9793,0 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга гараагүй байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар тайлант онд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө байхгүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 583914,6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 583914,6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан авч үзвэл орон нутгийн төсвөөс 583914,6 мянган төгрөгийн санхүүжилт авах төлөвлөгөө батлагдсаныг бүрэн авч, 583910,7 мянган төгрөгийг зарцуулан 3,9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй харьцуулан дүн шинжилгээ хийхэд батлагдсан төсвийг бүрэн авч зарцуулсан байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд төсөв батлагдаагүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 583910,7 мянган төгрөг буюу 100,0 хувьтай байна.

Нэмэлт төсөв: Нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 51700,8 мянган төгрөг төвлөрснөөс ЦАУЗБК-оос 1 иргэний нөхөн олговорт 40000,0 мянган төгрөг, төслийн сургалтын санхүүжилтээр 11700,8 мянган төгрөг тус тус төвлөрснийг зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 31 эрсдэлд горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 106022,1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 392,0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 103630,1 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 103630,1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. ИТХ-ын төлөөлөгч нарын тойрогтоо ажиллах зардалд 123000,0 мянган төгрөг батлагдсаныг бүрэн авч зарцуулсан байхад 12 төлөөлөгч зарцуулалтын тайлан ирүүлж, 29 төлөөлөгч 87000,0 мянган төгрөгийн зардлын зарцуулалтын тайлан ирүүлээгүй байна. ИТХ-ын хуралдааны зардалд 10000,0 мянган төгрөгийн төсөв батлагдаж 9443,0 мянган төгрөгийн зарцуулалт гарснаас 1 удаагийн 664,6 мянган төгрөгийн зарцуулалтад тушаал гарч, 8778,4 мянган төгрөгийн зарцуулалт шийдвэргүй

Энэ нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалт, санхүүгийн тайлангийн толилуулгын “Үнэлгээ”, “Хэмжилт”, “Үнэн зөв байдал” “Толилуулга ба тодруулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар ажил гүйлгээг тооцоо үүсгэлгүй зардалд бичсэн, төсвийн хөрөнгөөр худалдан авсан Соёрхол тэмдэг, "Хүндэтгэл"-ийг бараа материалын дансанд орлого аваагүй зарцуулж шууд зардлаар бүртгэсэн, хурлын хуралдааны хоолны зардлыг төсвийн захирагчийн шийдвэргүйгээр зарцуулсан зэрэг зөрчлүүдэд зөвлөмж өгсөн байхад хэрэгжүүлээгүй байна. Тайлант онд Соёрхол тэмдэг 600 ш-ийг 8000,0 мянган төгрөгөөр, Хүндэтгэл 600 ш-ийг 4290,0 мянган төгрөгөөр худалдан авсныг орлогод аваагүйгээр зардлаар бүртгэсэн, зарцуулалтыг шалгаж үзэхэд нотлох баримттай зарцуулагдсан Соёрхол тэмдэг 174 ш, үлдэгдэл 17ш байгаа бөгөөд 379 ш тэмдгийн зарцуулалт баримтгүй, "Хүндэтгэл" баримттай зарцуулсан 44 ш, тооллогоор үлдэгдэл 200 ш, баримтгүй зарцуулсан 356 ш байгаа бөгөөд аудитын явцад ирүүлсэн нэмэлт баримт нь нотлох баримтаар тооцох боломжгүй байна.

Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль"-ийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалт, санхүүгийн тайлангийн толилуулгын "Үнэлгээ", "Хэмжилт", "Үнэн зөв байдал" "Толилуулга ба тодруулга" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар илэрсэн шатахууны зарцуулалттай холбоотой зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал татахуйц асуудал байхгүй.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн ИТХ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг байршуулах үүрэгтэй.

2019 оны мэдээлэл оруулсан байдал дараах байдалтай байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9	2	
2	Хагас жил	4	4	1	3	
3	Улирал бүр	1	4	2	2	
4	Сар бүр	3	36	35	1	
	Тухай бүр	8	96	90	6	
	Нийт	27	151	137	14	

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар ажил гүйлгээг тооцоо үүсгэлгүй зардалд бичсэн, төсвийн хөрөнгөөр худалдан авсан Соёрхол тэмдэг, "Хүндэтгэл"-ийг бараа материалын дансанд орлого аваагүй зарцуулж шууд зардлаар бүртгэсэн, хурлын хуралдааны хоолны зардлыг төсвийн захирагчийн шийдвэргүйгээр

зарцуулсан зэрэг зөрчлүүдэд зөвлөмж өгсөн байхад хэрэгжүүлээгүй, өмнөх зөрчлүүд давтагдан гарч байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн ИТХ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай ” дүгнэлт

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Батлагдсан төсөв гүйцэтгэл

Илрүүлэлт

Төсвийн зарцуулалтыг анхан шатны баримттай тулган шалгахад зориулалтаараа зарцуулагдсан боловч зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл дутуу, шатахууны замын хуудсыг бүрэн бичээгүй, нярвын тайлан гаргалт хангалтгүй, тайлангаарх материалын орлого зарлагыг хүлээн авсан, өгсөн гарын үсэггүй зэрэг нь тухайн бараа материалын орлого, зарлага үнэн зөв эсэхийг нотлох боломжгүй нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль"-ийн 13.7, 14.3 дахь заалттай нийцэхгүй ба санхүүгийн тайлангийн толилуулгын Үнэлгээ", "Хэмжилт", "Үнэн зөв байдал" "Толилуулга ба тодруулга" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Эрсдэл

Төсвийн хөрөнгө үр ашиггүй, хяналтгүй зарцуулагдах, өр, авлага буруу илэрхийлэгдэх

Өгсөн зөвлөмж:

Бараа материалын тайланг заавар, журмын дагуу дахин үнэн зөв гаргаж, шатахууны зарцуулалтын замын хуудсыг бүрэн бичиж бүрдүүлэх.

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвшөөрсөн.

Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, гарсан үр дүнгийн талаар төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн дотор хариу ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>11,636,031.00</u>	<u>11,384,889.00</u>
33	АВЛАГА	2,689.00	2,689.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,689.00	2,689.00
34	УРЬДЧИЛГАА	251,142.00	00.00
3471	Урьдчилгаа тооцоо	251,142.00	00.00
34713	Цалингийн урьдчилгаа	251,142.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	11,382,200.00	11,382,200.00
354	Хангамжийн материал	11,382,200.00	11,382,200.00
35410	Бичиг хэргийн материал	833,110.00	833,110.00
35420	Аж ахуйн материал	10,549,090.00	10,549,090.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>21,354,420.26</u>	<u>30,977,402.75</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	21,354,420.26	30,977,402.75
392	Биет хөрөнгө	21,354,420.26	30,977,402.75
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,268,000.00	2,268,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,362,531.99	-1,400,331.99
39203	Авто-тээврийн хэрэгсэл	147,827,000.00	137,827,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-146,378,221.92	-137,327,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	54,944,333.00	60,980,313.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-44,914,018.04	-52,170,529.47
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,676,166.00	43,076,166.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,274,606.79	-22,844,514.79
39217	Ном	568,300.00	568,300.00
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>32,990,451.26</u>	<u>42,362,291.75</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,046,944.00</u>	<u>625,786.77</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,046,944.00	625,786.77
413	Өглөг	1,046,944.00	625,786.77
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,046,944.00	625,786.77
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>31,943,507.26</u>	<u>41,736,504.99</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	31,943,507.26	41,736,504.99
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	206,028,121.00	206,028,121.00
51101	Өмч: - төрийн	206,028,121.00	206,028,121.00
512	Хуримтлагдсан үр дүн	-176,488,279.74	-166,695,282.02

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51210	Өмнөх үеийн үр дүн	-176,488,279.74	-176,488,279.74
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	9,792,997.73
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,403,666.00	2,403,666.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	32,990,451.26	42,362,291.75

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	629,233,238.00	653,131,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	17,516,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	17,516,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	17,516,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	17,516,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	629,233,238.00	635,615,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	44,008,500.00	51,700,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,008,500.00	51,700,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	585,192,600.00	583,914,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	585,192,600.00	583,914,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	32,138.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	32,138.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	660,073,043.66	643,338,402.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	660,073,043.66	643,338,402.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	602,853,103.66	571,568,320.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	146,146,635.00	155,070,453.69
210101	Үндсэн цалин	102,142,164.00	143,737,133.69
210102	Нэмэгдэл	5,400,000.00	00.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,986,000.00	00.00
210104	Урамшуулал	30,618,471.00	11,333,320.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,489,914.00	19,421,029.08
210201	Тэтгэврийн даатгал	15,837,744.00	13,222,002.16
210202	Тэтгэмжийн даатгал	443,909.00	1,549,758.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	355,127.00	1,239,805.58

**Баянхонгор аймгийн ИТХ-ын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210204	Ажилгүйдлийн даатгал	88,781.00	309,950.15
210205	Эрүүл мэндийн даатгал	764,353.00	3,099,512.46
2104	Хангамж, бараа материалын зардал	37,822,397.00	33,037,810.00
210401	Бичиг хэрэг	2,710,380.00	5,305,690.00
210402	Тээвэр, шатахуун	32,300,330.00	24,781,390.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,811,687.00	2,950,730.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,955,410.00	5,972,000.00
210602	Тавилга	00.00	1,100,000.00
210604	Урсгал засвар	14,955,410.00	4,872,000.00
2107	Томилолт, зочны зардал	67,200,000.00	68,177,800.00
210701	Гадаад албан томилолт	58,426,000.00	60,000,000.00
210702	Дотоод албан томилолт	8,774,000.00	8,177,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,210,411.00	140,410,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,973,411.00	139,000,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,060,000.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	810,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	150,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	292,028,336.66	149,478,427.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	209,983,850.00	138,165,430.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	54,070,550.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,973,936.66	11,312,997.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,219,940.00	71,770,082.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,157,109.00	71,766,200.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	32,138.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,970,000.00	44,469,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,154,971.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,000,000.00	27,296,700.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	62,831.00	3,882.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	62,831.00	3,882.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-30,839,805.66	9,792,997.73
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	21,807,680.07	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	21,807,680.07	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-21,807,680.07	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-52,647,485.73	9,792,997.73

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	629,233,238.00	635,615,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	629,233,238.00	635,615,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	44,008,500.00	51,700,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,008,500.00	51,700,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	585,192,600.00	583,914,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	585,192,600.00	583,914,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	32,138.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	32,138.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	629,267,438.00	635,615,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	629,267,438.00	635,615,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	572,047,498.00	563,845,318.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	146,280,901.00	155,254,598.00
210101	Үндсэн цалин	85,963,200.00	94,729,198.00
210102	Нэмэгдэл	2,403,000.00	00.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,986,000.00	7,986,000.00
210104	Урамшуулал	49,928,701.00	52,539,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,553,700.00	19,406,900.00
210201	Тэтгэврийн даатгал	15,060,297.00	13,196,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	623,351.00	1,552,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	498,680.00	1,242,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	124,669.00	310,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,246,703.00	3,105,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,667,397.00	24,095,200.00
210401	Бичиг хэрэг	2,708,260.00	1,705,190.00
210402	Тээвэр, шатахуун	24,147,450.00	19,439,280.00

**Баянхонгор аймгийн ИТХ-ын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,811,687.00	2,950,730.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,600,000.00	6,500,000.00
210602	Тавилга	00.00	1,100,000.00
210604	Урсгал засвар	11,600,000.00	5,400,000.00
2107	Томилолт, зочны зардал	67,200,000.00	68,177,800.00
210701	Гадаад албан томилолт	58,426,000.00	60,000,000.00
210702	Дотоод албан томилолт	8,774,000.00	8,177,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,275,500.00	140,410,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,038,500.00	139,000,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,060,000.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	810,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	150,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	272,470,000.00	150,000,020.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	218,399,450.00	150,000,020.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	54,070,550.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,219,940.00	71,770,082.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,157,109.00	71,766,200.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	32,138.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,970,000.00	44,469,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,154,971.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,000,000.00	27,296,700.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	62,831.00	3,882.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	62,831.00	3,882.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-34,200.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-34,200.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	34,200.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	206,028,121.00	2,403,666.00	123,840,794.01	00.00	84,590,992.99
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	206,028,121.00	2,403,666.00	123,840,794.01	00.00	84,590,992.99
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-52,647,485.73	00.00	-52,647,485.73
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	206,028,121.00	2,403,666.00	176,488,279.74	00.00	31,943,507.26
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	206,028,121.00	2,403,666.00	176,488,279.74	00.00	31,943,507.26
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	206,028,121.00	2,403,666.00	176,488,279.74	00.00	31,943,507.26
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	9,792,997.73	00.00	9,792,997.73
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	206,028,121.00	2,403,666.00	166,695,282.02	00.00	41,736,504.99

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		34200.0		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	585,192,600.00	585,163,969.00	583,914,600.00	583,910,718.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	585,192,600.00	585,163,969.00	583,914,600.00	583,910,718.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	528,067,600.00	525,038,998.00	553,644,600.00	553,644,518.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	146,281,100.00	146,280,901.00	155,254,600.00	155,254,598.00
210101	Үндсэн цалин	85,963,200.00	85,963,200.00	94,729,200.00	94,729,198.00
210102	Нэмэгдэл	00.00	2,403,000.00	00.00	00.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,986,000.00	7,986,000.00	7,986,000.00	7,986,000.00
210104	Урамшуулал	52,332,000.00	49,928,701.00	52,539,400.00	52,539,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,199,100.00	17,553,700.00	19,406,900.00	19,406,900.00
210201	Тэтгэврийн даатгал	11,820,300.00	15,060,297.00	13,196,800.00	13,196,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,433,300.00	623,351.00	1,552,500.00	1,552,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,146,700.00	498,680.00	1,242,000.00	1,242,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	286,700.00	124,669.00	310,500.00	310,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,866,700.00	1,246,703.00	3,105,100.00	3,105,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,695,800.00	26,667,397.00	24,095,200.00	24,095,200.00
210401	Бичиг хэрэг	2,678,000.00	2,708,260.00	1,678,000.00	1,705,190.00
210402	Тээвэр, шатахуун	23,517,800.00	24,147,450.00	19,417,200.00	19,439,280.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,000,000.00	2,811,687.00	3,000,000.00	2,950,730.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	00.00	00.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,600,000.00	11,600,000.00	6,500,000.00	6,500,000.00
210602	Тавилга	00.00	00.00	1,500,000.00	1,100,000.00
210604	Урсгал засвар	11,600,000.00	11,600,000.00	5,000,000.00	5,400,000.00
2107	Томилолт, зочны зардал	67,200,000.00	67,200,000.00	68,177,800.00	68,177,800.00
210701	Гадаад албан томилолт	6,000,000.00	58,426,000.00	60,000,000.00	60,000,000.00
210702	Дотоод албан томилолт	7,200,000.00	8,774,000.00	8,177,800.00	8,177,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,537,000.00	7,537,000.00	130,210,000.00	130,210,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,300,000.00	5,300,000.00	127,800,000.00	128,800,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	100,000.00	200,000.00	200,000.00

**Баянхонгор аймгийн ИТХ-ын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210803	Даатгалын үйлчилгээ	2,060,000.00	2,060,000.00	250,000.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	77,000.00	77,000.00	810,000.00	810,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	00.00	150,000.00	150,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	00.00	1,000,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	248200000.00	248200000.00	150000100.00	150000020.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	215,800,000.00	215,800,000.00	150,000,100.00	150,000,020.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	32,400,000.00	32,400,000.00	00.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57125000.00	57125000.00	30270000.00	30266200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	00.00	30,270,000.00	30,266,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,970,000.00	2,970,000.00	2,970,000.00	2,969,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,155,000.00	30,154,971.00	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,000,000.00	24,000,000.00	27,300,000.00	27,296,700.00
132001	Орон нутгийн төсвөөс	585,192,600.00	585,129,769.00	00.00	00.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	34,200.00	00.00	00.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	11.00	11.00	11.00	11.00
620001	Удирдах ажилтан	04.00	04.00	04.00	04.00
620002	Гүйцэтгэх ажилтан	02.00	02.00	02.00	02.00
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	05.00	05.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	11.00	11.00	11.00	11.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	02.00	02.00	02.00	02.00
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	03.00	03.00	03.00	03.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	06.00	06.00	06.00	06.00

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	44008500.00	51,700,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	44008500.00	51,700,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	44008500.00	51,700,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44008500.00	10,200,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44008500.00	10,200,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	41500000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		41,500,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		41,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44008500	51,700,800.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН: ГЭРЭЭТ АУДИТОР

Д.ЦЭЦЭГМАА

АНХАН ШАТАНД ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

ХОЁРДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

Огноо: 2020.02.27

